НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/007/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он


Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Цолмон
Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn

Аудитор: М.Өлзийхишиг
Утас: 325093 Цахим хаяг: ulziikhishigm@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ......................................................................2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ................................4**

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..........................** Error! Bookmark not defined.

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ................................................**Error! Bookmark not defined.**

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .............................................**Error! Bookmark not defined.**

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....................................**Error! Bookmark not defined.**

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд **Error! Bookmark not defined.**

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.................................**Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН.........................................................** Error! Bookmark not defined.

**4.1 Ерөнхий зүйл**.......................................................................**Error! Bookmark not defined.**

**4.2 Материаллаг байдал**..............................................................**Error! Bookmark not defined.**

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ................**Error! Bookmark not defined.**

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**.....**Error! Bookmark not defined.**

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**.......... **Error! Bookmark not defined.**

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..............................**Error! Bookmark not defined.**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.......................................................** Error! Bookmark not defined.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......................................16**


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХҮЕГ | Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар |
| ГБХНХЯ | Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яам |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| НТАГ | Нийслэлийн төрийн аудитын газар |
| АХЭ | Ахмадыг хөдөлмөр эрхлэлт |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |

НБББББ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026 · 02 · 25 № 174

танай ____________-ны № ____________-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Б.ЭРДЭНЭБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант оны 2,376.8 сая төгрөгийн авлагын эцсийн үлдэгдэлтэй, үүнээс хугацаа хэтэрсэн 741.2 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлж барагдуулахаар арга хэмжээ авч ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2025 онд 826.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулж ажилласан байна.

1426950283

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***/төгрөгөөр/***

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,482,761,878.67** | **2,376,803,896.41** |
| **33** | **АВЛАГА** | 2,482,761,878.67 | 2,376,803,896.41 |
| **335** | **Бусад авлага** | 2,482,761,878.67 | 2,376,803,896.41 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,482,761,878.67 | 2,376,803,896.41 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,482,761,878.67** | **2,376,803,896.41** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **394,742,192.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 394,742,192.00 |
| **413** | **Өглөг** | - | 394,742,192.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 394,742,192.00 |
| 41361 | Санхүүгийн дэмжлэгийн өглөг | | 394,742,192.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,482,761,878.67** | **1,982,061,704.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,482,761,878.67 | 1,982,061,704.41 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,482,761,878.67 | 1,982,061,704.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,775,629,767.62 | 2,482,761,878.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (292,867,888.95) | (500,700,174.26) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,482,761,878.67** | **2,376,803,896.41** |
| | | | |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,243,388,300.00** | **1,783,627,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **248,990,000.00** | **297,177,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 248,990,000.00 | 297,177,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 248,990,000.00 | 297,177,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 248,990,000.00 | 297,177,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,994,398,300.00** | **1,486,450,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,994,398,300.00 | 1,486,450,700.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,994,398,300.00 | 1,486,450,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,536,256,188.95** | **2,284,327,874.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,536,256,188.95** | **2,284,327,874.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 63,044,975.00 | 53,935,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,044,975.00 | 53,935,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,044,975.00 | 53,935,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,473,211,213.95 | 2,230,392,674.26 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 543,761,250.00 | 667,565,656.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 543,761,250.00 | 667,565,656.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,929,449,963.95 | 1,562,827,018.26 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,929,449,963.95 | 1,562,827,018.26 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(292,867,888.95)** | **(500,700,174.26)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(292,867,888.95)** | **(500,700,174.26)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,695,890,160.00** | **1,783,627,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **701,491,860.00** | **297,177,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 701,491,860.00 | 297,177,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 701,491,860.00 | 297,177,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 248,990,000.00 | 297,177,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,994,398,300.00** | **1,486,450,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,994,398,300.00 | 1,486,450,700.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,994,398,300.00 | 1,486,450,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,474,756,188.95** | **2,715,585,682.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,474,756,188.95** | **2,715,585,682.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **63,044,975.00** | **53,935,200.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,044,975.00 | 53,935,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,044,975.00 | 53,935,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,411,711,213.95** | **2,661,650,482.26** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,482,261,250.00 | 1,098,823,464.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,482,261,250.00 | 1,098,823,464.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,929,449,963.95 | 1,562,827,018.26 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,929,449,963.95 | 1,562,827,018.26 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(778,866,028.95)** | **(931,957,982.26)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 778,866,028.95 | 931,957,982.26 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 778,866,028.95 | 931,957,982.26 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **778,866,028.95** | **931,957,982.26** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | - | 2,775,629,767.62 | 2,775,629,767.62 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | - | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | - | -292,867,888.95 | -292,867,888.95 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | - | 2,482,761,878.67 | 2,482,761,878.67 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | - | 2,482,761,878.67 | 2,482,761,878.67 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | - | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | - | -500,700,174.26 | -500,700,174.26 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | - | **1,982,061,704.41** | **1,982,061,704.41** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/*төгрөгөөр*/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,110,480,840.00 | 1,152,758,664.00 | 957,722,176.00 | 54.62 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,110,480,840.00 | 1,152,758,664.00 | 957,722,176.00 | 54.62 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 67,780,000.00 | 53,935,200.00 | 13,844,800.00 | 79.57 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 67,780,000.00 | 53,935,200.00 | 13,844,800.00 | 79.57 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,780,000.00 | 53,935,200.00 | 13,844,800.00 | 79.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,042,700,840.00 | 1,098,823,464.00 | 943,877,376.00 | 53.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,042,700,840.00 | 1,098,823,464.00 | 943,877,376.00 | 53.79 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,042,700,840.00 | 1,098,823,464.00 | 943,877,376.00 | 53.79 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,110,480,840.00 | 2,715,585,682.26 | (605,104,842.26) | 128.67 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,249,280,840.00 | 1,486,450,700.00 | (237,169,860.00) | 118.98 |
| **1320** | **САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ** | 650,000,000.00 | 931,957,982.26 | (281,957,982.26) | 143.38 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/*төгрөгөөр*/

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2025 онд ахмадын санхүүгийн дэмжлэг олгосон иргэдээс 1 нэр бүхий иргэн 12 сард эргэн төлөлт хийгээгүй хугацаа хэтрүүлсэн байна. | 1 | 906.0 | | | | | 1 | 906.0 |
| Нас барсан иргэдийн авлагад эрсдлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НББББББ-т тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | **2** | | | | | | **2** | 906.0 |